МЭДЭЭ · 2021 оны 5-р сарын 19

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ ЗӨРЧИХ ЗӨРЧЛИЙГ СУДАЛЖЭЭ



Баян-Өлгий аймгийн прокурорын газраас Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлд заасан Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих зөрчлийн хэргийн гаралт, шийдвэрлэлтийг судалж, холбогдох арга хэмжээг авчээ.

Тус аймгийн хэмжээнд энэ оны эхний 4 сарын байдлаар Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих зөрчлийн хэрэг нийт 40 бүртгэгдэж, 28 хүн, 1 хуулийн этгээд торгох, 4 хүн баривчлах шийтгэл тус тус хүлээсэн байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.2 дахин өссөн үзүүлэлттэй байгаа ажээ.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 5 дугаар сарын 11-ны өдөр Улаанбаатар хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

5.13 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих

1.Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед энэ талаар олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээ, мэдээлэл түгээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй БОЛ ХҮНИЙГ 500.000 ТӨГРӨГӨӨР, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ 5.000.000 ТӨГРӨГӨӨР ТОРГОНО.

2.Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед эрх бүхий байгууллагаас тогтоосон хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт, тэдгээрийн дэглэм зөрчсөн, эсхүл саад учруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй БОЛ ХҮНИЙГ 500.000 ТӨГРӨГӨӨР ТОРГОХ, ЭСХҮЛ 7-30 ХОНОГИЙН ХУГАЦААГААР БАРИВЧЛАХ ШИЙТГЭЛ ОНОГДУУЛАХ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ 5.000.000 ТӨГРӨГӨӨР ТОРГОНО.

3.Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед эрх бүхий байгууллагаас өгсөн мэдээ, мэдээллийг үнэ төлбөргүйгээр, саадгүйгээр мэдээлэх үүргээ биелүүлээгүй БОЛ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ 5.000.000 ТӨГРӨГӨӨР ТОРГОНО.

4.Гамшгаас хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй БОЛ ХҮНИЙГ 100.000 ТӨГРӨГӨӨР, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ 1.000.000 ТӨГРӨГӨӨР ТОРГОНО.

5.Гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюул, гамшгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор байгуулсан барилга байгууламжийг эвдэж гэмтээсэн, эсхүл зориулалтыг дур мэдэн өөрчилсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй БОЛ УЧРУУЛСАН ХОХИРОЛ, НӨХӨН ТӨЛБӨРИЙГ ГАРГУУЛЖ ХҮНИЙГ 500.000 ТӨГРӨГӨӨР, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ 5.000.000 ТӨГРӨГӨӨР ТОРГОНО.

6.Тусламж үзүүлэгч хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан БОЛ ХҮНИЙГ 100.000 ТӨГРӨГӨӨР, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ 1.000.000 ТӨГРӨГӨӨР ТОРГОНО.

www.prokuror.mn

Нийт зөрчлийн хэргийг судлахад эрх бүхий байгууллагаас тогтоосон хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт, тэдгээрийн дэглэм зөрчсөн зөрчлүүд зонхилон гарсан байна. Ялангуяа гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед хязгаарласан үйл ажиллагаа явуулсан, архи согтууруулах ундааны зүйлийг нууцаар зарсан, хурим найр, цайллага гэх мэт олон нийтийн арга хэмжээ зохион байгуулсан, гэрийн ажиглалтад байх хугацааг зөрчсөн, эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, шинжилгээний бичиггүйгээр хот хоорондын хөдөлгөөнд оролцсон зэрэг зөрчлүүд түгээмэл үйлдэгджээ.

Иймээс Баян-Өлгий аймгийн прокурорын газраас орон нутгийн телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих зөрчлийн хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх талаар иргэдэд мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулсан байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2901